



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/105

Мандалговь

"Мандал шилтгээн" ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Бүрдийн уянга хүүхдийн зуслангийн дээврийн засвар" ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Мандал шилтгээн" ХХК-тай 148,134,854 (нэг зуун дөчин найман сая нэг зуун гучин дөрвөн мянга найман зуун тавин дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зургийн даалгаврын дагуу "Бүрдийн уянга хүүхдийн зуслангийн дээврийн засвар" ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Мандал шилтгээн" ХХК-ийн захирал (Б.Ням)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150233